

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Л.ГАНБОЛД

(Гарын үсэг)

ГҮЙЦЭТГЭГЧ:

"ЭРХЭТ ХҮМҮҮН" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.МӨНХ-ЭРДЭНЭ

(Гарын үсэг)

АХМАДЫН ӨРГӨӨНИЙ БАРИЛГА БАРИЛГА ХУДАЛДАН
АВАХ /ХӨВСГӨЛ, ТӨМӨРБУЛАГ СУМ/ ГЭРЭЭ

Дугаар № r-ХНХЯ/202002022/1.3.8

2020 оны 7 дугаар сарын 02-ны өдөр

Хөвсгөл аймаг

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг талаас Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Ганболд (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас "Эрхэт хүмүүн" ХХК-ийн захирал Ц.Мөнх-Эрдэнэ (цаашид "нийлүүлэгч" гэх) нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1.1 Захиргааны ерөнхий хууль, Иргэний хууль, Барилгын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.2 Захиалагч нь *Ахмадын өргөөний барилга худалдан авах /Хөвсгөл, Төмөрбулаг сум/ r-ХНХЯ/202002022/1.3.8 дугаартай бараа-г* (цаашид "бараа" гэх) **200,000,000 (Хоёр зуун сая)** төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

1.3 Захиалагч нь барааны нийлүүлэлтийг **200,000,000 (Хоёр зуун сая)** төгрөгийн Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ. Үүнээс
2020 онд: 200,000,000 /Хоёр зуун сая/ төгрөг

1.4 Нийлүүлэгч нь *Ахмадын өргөөний барилгыг* 2020 оны 07 дугаар сарын 02 –ны өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.


1.5 Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх).
Үүнд:

- Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- Бусад шаардлагатай баримт бичиг¹;
- Тендер ба үнийн хуваарь;
- Гэрээний ерөнхий нөхцөл;
- Гэрээний тусгай нөхцөл;
- Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
- Санхүүжилтийн хуваарь.


ХААН банкны 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр гаргасан GU20200701110919 дугаартай 10,000,000 (Арван сая) төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа.

¹ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:



1.6 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

1.7 Гэрээ нь энд дурдсан бараа нийлүүлэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

1.8 Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл түүний хавсралтад заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлж, хариуцлагыг хүлээнэ.

1.9 Гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн баталгааг барааг нийлүүлсэн тухай мэдэгдэл (Барааг хүлээн авах акт) гарснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байлгана. Бараа нийлүүлэлт дуусаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгааг чөлөөлөхийг хориглох бөгөөд баталгаа чөлөөлсөн нөхцөлд захиалагчийн шийдвэрээр гэрээг цуцлана.

1.10 Барааны баталгаат засварын хугацаа буюу барааны чанарын баталгааны хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг сүүлийн санхүүжилтээс суутган тооцож 1 жилийн хугацаанд Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн дансанд байршуулна.

1.11 Барааг захиалагчийн ажлын хэсэгт хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацааны 1 жилийн хугацаанд бараанд гарсан гэмтэл согог, зөрчил, гологдлыг засварлах шаардлага гарсан тохиолдолд захиалагч нь гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэнэ. Гүйцэтгэгч нь захиалагчийн хүсэлтийн дагуу зөрчил гологдлыг арилгах, шинэ бараагаар солих үүрэг хүлээнэ.

1.12 Нийлүүлэгч нь гэрээний 1.11 дахь хэсэгт заасан мэдэгдэл авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гүйцэтгээгүй тохиолдолд захиалагч энэхүү гэрээний 1.10 дахь хэсэгт заасан барьцаа хөрөнгөөс гарган гологдол, гэмтлийг арилгах ажлыг бусад этгээдээр гүйцэтгүүлэх буюу үүргээ гүйцэтгээгүй нийлүүлэгчийг "Тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл"-д бүртгүүлэхээр холбогдох байгууллагад хандана.

1.13 Бараа нийлүүлэх гэрээний төлбөрийг санхүүжилтийн хуваарийн дагуу гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжүүлэх бөгөөд гэрээний төлбөрийн үлдэгдлийг барааг бүрэн нийлүүлж, холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгсний дараа олгоно.

1.14 Бараа нийлүүлэх гэрээний төлбөр нь нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөхгүй.

1.15 Зайлшгүй шаардлагаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож гэрээний үнэ, барааны техникийн тодорхойлолтоос бусад асуудлаар зохих өөрчлөлт оруулж болох бөгөөд тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд хүчин төгөлдөр болсонд тооцно.

1.16 Нийлүүлэгчид олгох гэрээний төлбөрөөс дараах зардлуудыг захиалагчийн холбогдох дансанд суутгана. Үүнд:

- Гэрээ байгуулах бичиг хэргийн материалын үнэ, барааг хүлээн авах, түршилт тохируулга хийх, ашиглалтад оруулах, чанарын баталгааны барьцаа хөрөнгийг чөлөөлөхөд ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай зардал: **400,000 (Дөрвөн зуун мянган)** төгрөг
- Барааг захиалагч хүлээн авахаас өмнө гарсан урсгал зардал **0,0** төгрөг

1.17 Захиалагч нь Иргэний хуулийн 254 дүгээр зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлнэ.

1.18 Нийлүүлэгч нь Иргэний хуулийн 253 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлнэ.

1.19 Захиалагч нь гэрээний дагуу бараа нийлүүлэлт болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөр төлөх, чанарын баталгааны барьцаа хөрөнгийг чөлөөлөн нийлүүлэгчид олгох үүрэг хүлээнэ.


1.20 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.

ХОЁР.ГЭРЭЭНИЙ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА


2.1 Нийлүүлэгч нь барааны тендерт өөрийн ирүүлсэн баримт бичиг, ажлын гүйцэтгэлийн талаар бүрдүүлж өгсөн зураг, төсөв, баримт материалын үнэн зөвийг бүрэн хариуцна.

2.2 Талууд бие биенийхээ өмнөөс гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:



2.3 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэхгүй. Шилжүүлсэн тохиолдолд үүсэх үр дагаварыг шилжүүлсэн тал өөрөө хариуцна.

2.4 Захиалагч гэрээний тусгай нөхцлийн 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.5 дэх хэсэгт заасан туршилт, шалгалтыг явуулсан нь аль ч нөхцөл, болзол нийлүүлэгчийг гэрээний баталгаат засварын болон бусад үүргээс чөлөөлөхгүй.

2.5 Гэрээний тусгай нөхцөл (ГЕН – 9)-ийн 9.3, 9.4 дахь хэсэгт заасан баримт бичгийг барааг хүргэх газар, эсхүл боомтод ирэхээс 7 хоногийн өмнө захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

2.6 Талуудын санаачлагаар гэрээг цуцалсан тохиолдолд гэрээг дүгнэж хохиролыг тооцож хохирол тооцсон мэдэгдлийг хариуцагч талд хүргүүлж, гэм буруутай тал хохиролыг барагдуулна.

2.7 Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг захиалагчийн санаачлагаар болоннийлүүлэгчийн хүсэлтээр цуцалсан тохиолдолд нийлүүлэгчээс гаргасан “гүйцэтгэлийн баталгаа”-г захиалагчийн өмчлөлд “үл маргах журам”-аар шилжүүлэх үүргийг баталгаа гаргагч банк хариуцана..

2.8 Гэрээнд хамаарах хууль тогтоомжийн холбогдох заалт болон энэ гэрээний ерөнхий нөхцөл, захиалагч, нийлүүлэгчийн эрх, үүрэг, тусгай нөхцөл, бусад нөхцөлийг зөрчсөн тал “Захиргааны ерөнхий хууль”-ийн 56 дугаар зүйлийн 56.1, “Иргэний хууль”-ийн 222 дугаар зүйлийн 222.4, 223 дугаар зүйлийн 223.1, 223.2, 225 дугаар зүйлийн 225.5, 227 дугаар зүйлийн 227.1, 227.3, 227.5, 229 дүгээр зүйлийн 229.1, 230 дугаар зүйлийн 230.1, 230.2, 231 дүгээр зүйлийн 231.1.1, 231.1.3, 232 дугаар зүйлийн 232.6, 234 дүгээр зүйлийн 234.4, 249 дүгээр зүйлийн 249.1, 349 дүгээр зүйлийн 349.1, 355 дугаар зүйлийн 355.6, 457 дугаар зүйлийн 457.10 дахь хэсгүүдэд заасан хариуцлагыг хүлээнэ.

2.9 Талуудын санаачлагаар гэрээг цуцалсан тохиолдолд гэрээг дүгнэж хохиролыг тооцож хохирол тооцсон мэдэгдлийг хариуцагч талд хүргүүлж, гэм буруутай тал хохиролыг барагдуулна.

2.10 Гэрээг нийлүүлэгчийн хүсэлтээр цуцалсан тохиолдолд нийлүүлэгч дараах хариуцлагыг хүлээнэ. Үүнд: 1. Нийлүүлэгчийг “Тендерг орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл”-д бүртгүүлэх хүсэлтийг захиалагчаас санаачлан холбогдох байгууллагад хүргүүлнэ.

2.11 Гэрээ цуцалсны улмаас захиалагчид учирсан хохирол (Санхүүжилт татагдах, тендер зарлах, гэрээ байгуулах, барааг судлах, ирээдүйд олохоор тооцон үр ашиг)-ыг нийлүүлэгч хариуцан барагдуулна.

ГУРАВ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ ҮНДЭСЛЭЛ.

Гэрээг дор дурьдсан үндэслэлээр цуцална.

3.1 Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад арга хэрэгслийг ашиглалгүйгээр нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Үүнд:

3.1.1 Гэрээний ерөнхий нөхцлийн “Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах” гэсэн ерөнхий нөхцлийн 18.1 дэх хэсэгт заасан үндэслэл

3.1.2 Гэрээний ерөнхий нөхцлийн “Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах” гэсэн ерөнхий нөхцлийн 19.1 дэх хэсэгт заасан үндэслэл

3.1.3 Гэрээний ерөнхий нөхцлийн “Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах” гэсэн ерөнхий нөхцлийн 20.1 дэх хэсэгт заасан үндэслэл


3.1.4 Захиргааны ерөнхий хуулийн 56 дугаар зүйлийн 56.2, 56.3, “Иргэний хууль”-ийн 221 дүгээр зүйлийн 221.3, 225 дугаар зүйлийн 225.3, 225.7, 240 дүгээр зүйлийн 240.1.2, 249 дүгээр зүйлийн 249.1, 356 дугаар зүйлийн 356.1, 356.2, 356.3 дахь хэсгүүдэд заасан нөхцөл байдал бий болсон

ДӨРӨВ. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ


4.1. Гэрээг 5 хувь үйлдэж захиалагч тал гурав, гүйцэтгэгч тал 2 хувийг хадгална. Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдөр гэрээ хүчин төгөлдөр болно.

4.2 Сангийн сайдын 2012 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 81 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Бараа худалдан авах ажиллагаа”-ны тендерийн жишиг баримт бичгийн гэрээний ерөнхий

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:



нөхцөл, гүйцэтгэлийн баталгаа болон энэ гэрээний 1.5 дахь хэсэгт заасан баримт бичгүүд нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3 Энэхүү гэрээний нөхцөлд гэрээнд заасан барааны техникийн тодорхойлолт, тоо хэмжээ, үнэ өөрчлөхөөс бусад асуудлаар өөрчлөлт оруулж болох бөгөөд уг өөрчлөлт нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

ТАВ. ГЭРЭЭ ДҮГНЭХ

5.1 Захиалагчийн төслийн баг нь нийлүүлэгч байгууллагатай хамтран барааг захиалагчид хүлээн авах ажиллагааг зохион байгуулж, бараа нийлүүлэх гэрээг дүгнэнэ.

5.2 Бараа нийлүүлэлтийн үндсэн гэрээ болон нэмэлт гэрээг тухайн үе шатанд хийгдсэн нийлүүлэлт, гэрээний бусад нөхцлийг үндэслэн дүгнэнэ.

ГЭРЭЭНИЙ НӨХЦЛИЙГ ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗДТГ-ЫН ДАРГА


Г.ГАН-ОЧИР

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын "А" байр
Утасны дугаар: 70388699

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗРЫН ДАРГА


Б.БОЛД

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын "А" байр
Утасны дугаар:
70388849 • 4131053

ХЯНАСАН:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ "ЭРХЭТ ХҮМҮҮН" ХХК-ИЙН
ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР


Г.ГАНДЭЛГЭР

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын "А" байр
Утасны дугаар: 70382751

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


Д.БАЯНЖАРГАЛ

Улаанбаатар хот, ХУД, 15 дугаар
хороо, 32-2-3 тоот


Утас: 99993796, 88783025

Харилцагч банкны нэр: ХААН
банк


Дансны дугаар: 5916090422

Регистрийн дугаар: 4141334

Захиалагчийг төлөөлж: _____




Гүйцэтгэгчийг төлөөлж: _____




ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Гэрээний ерөнхий нөхцөлийн заалтын дугаар	Ерөнхий нөхцөлийн дэд дугаар	Тусгай нөхцөлийн заалт
1. Тодорхойлолт (ГЕН - 1)	1.1.(д)	Захиалагч нь <i>Хөвсгөл аймгийн Засаг дарга</i> .
	1.1	Төсөл арга хэмжээний нэр: <i>Ахмадын өргөөний барилга худалдан авах /Хөвсгөл, Төмөрбулаг сум/</i>
	1.1	Гэрээний дугаар: г-ХНХЯ/202002022/1.3.8
	1.1(г)	Бусад үйлчилгээ “Шаардлагатай” ”Үгүй” гэх сонголтыг дараах үйлчилгээний ард нь тэмдэглэнэ. Үүнд: 1. тээвэрлэлт- <i>шаардлагагүй</i> 2. даатгал болон бусад дагалдах үйлчилгээ - <i>шаардлагатай</i> 3. угсралт – <i>үгүй /баригдсан барилга/</i> 4. техникийн туслалцаа - <i>шаардлагатай</i> 5. сургалт - <i>үгүй</i>
	1.1 (ж)	Барааг <i>Барилга байгууламжийн байрлаж буй газарт хүлээн авна.</i>
6. Шалгалт туршилт (ГЕН - 7)	7.1	Барааг тээвэрлэхээс өмнө захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол Улсад орж ирсэний дараа түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох захиалагчийн эрхийг хөндөхгүй.
	7.2	Нийлүүлэгч нь барааг захиалагчаас тогтоосон цэгт хүргэхийн өмнө түүний техникийн тодорхойлолт, үйлдвэрийн өгөгдөл, гарал үүслийн гэрчилгээ, техникийн паспорт зэрэг баримт бичгийг ирүүлж, ба захиалагч нь барааг хүлээн авах эсэх санал болон барааг шалгаж туршихаар томилогдсон төлөөлөгч(д)-ийг мэдээллийг албан бичгээр нийлүүлэгчид хүргүүлнэ.
	7.3	Гэрээний тусгай нөхцөлд заасан газарт ирүүлсэн бараанд дараах шалгалт, туршилтыг хийнэ. Үүнд: Захиалагчийн техникийн тодорхойлолт, холбогдох стандартын заалт нэг бүрийг хангаж буй эсэхийг нийлүүлэхээр санал болгосон барааны үйлдвэрийн өгөгдөл, техникийн паспорт, гарал үүслийн гэрчилгээнд заасан өгөгдөлтэй нэг бүрчлэн тулгаж шалгана.
	7.4	Барилга байгууламжийг хүлээн авахдаа барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-аар магадлалыг дүгнэлттэй зураг төсөвтэй тулган шалгаж барилга байгууламжийг барих ил болон далд ажлын актын баталгаажилт, улсын комиссын актыг үндэслэн хүлээн авна.
	7.5	Барааны зориулалт, шинж чанар, онцлог байдлаас хамааруулж бусад туршилт, шалгалтыг явуулж болно.
7. Баглаа боодол (ГЕН - 8)	8.1	Хүлээлгэн өгөх барилга нь ахмадын өргөөний зориулаллалтаар ашиглагахад стандарт шаардлагыг хангасан тухай мэргэжлийн байгууллагын дүгнэлт шийдвэртэй байна. Ашиглалтад хүлээлгэн өгөхдөө барилга гэрээний 4 дүгээр хавсралт техникийн нөхцөлд заасан баримтыг бүрдүүлсэн байна.
8. Барааг хүргэх болон бичиг баримтын	9.0	ГЕН-ийн 9 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: ¹² “Монгол Улсын гаднаас санал болгосон бараа жишээлбэл СИП: Нийлүүлэгч барааг тээврийн хэрэгсэлд ачсаны дараа энэ тухай бүрэн мэдээллийг захиалагч болон даатгалын байгууллагад утсан

Захиалагчийг төлөөлж:




Гүйцэтгэгчийг төлөөлж:




		<p>1. Урьдчилгаа төлбөр: Хэрэв тендерийн баримт бичигт заасан тохиолдолд гэрээний үнийн 10 хувьтай тэнцэх дүнг гэрээнд гарын үсэг зурснаас хойш 30 хоногийн дотор гүйцэтгэгчийн гаргаж ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн төлнө. Урьдчилгаа төлбөрийн баталгаа нь бараа нийлүүлэгдэх хүртэлх хугацаанд хүчинтэй, урьдчилгаа төлбөрийн хэмжээтэй тэнцэх дүнтэй, тендерийн баримт бичигт заасан маягтын дагуу захиалагч хүлээн зөвшөөрөхүйц банкны баталгаа, Засгийн газрын бонд хэлбэрээр байна.</p> <p>2. Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр: Бараа ачигдсаны дараа барааны гэрээний үнийн 70 хувьтай тэнцэх дүнг гэрээний ерөнхий нөхцөлийн 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийг үндэслэн буцаан үл дуудах баталгаат аккредитивээр төлнө.</p> <p>3.¹⁴ Барааг хүлээн авахад төлөх төлбөр: Гэрээний төлбөрийн үлдэгдэл (20 хүртэл хувь)-ийг барааг бүрэн хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх болон гэрээг дүгнэсэн акт, захиалагчийн барааг хүлээн авсан тухай акт, бусад баримт бичгийг үндэслэн төлнө.</p>
13. Үнэ (ГЕН - 15)	15.1	<p>1. Барааны суурь үнэ 15%¹⁷ хувиас илүү өсөх, эсхүл буурахаар бол үнийг тохируулах бусад тохиолдолд үнэ тохируулахгүй.</p> <p>2. Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон үнийг баримтлана.</p> <p>3. Захиалгыг өөрчлөхгүй.</p> <p>4. Тендерт оролцогч индексийн эх үүсвэр болон суурь өдрийн индексийг өөрийн тендерт зааж өгнө. Суурь өдөр нь тендер зарласан өдөр байна.</p>
14. Бараа нийлүүлэлтийн хуваарийг сунгах (ГЕН - 16)	16.2	<p>Нийлүүлэгч гэрээ болон нийлүүлэлтийн хуваарийг сунгах хүсэлтийг гэрээний нийлүүлэлтийн хуваарь дуусахаас 7-оос доошгүй хоногийн өмнө захиалагчид бичгээр гаргана. Захиалагч нийлүүлэгчийн хүсэлтийг судлан “Гэрээний ерөнхий нөхцлийн “Хуваарийг сунгах” гэх гэрээний ерөнхий нөхцлийн 16.2 дахь хэсэгт заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд гэрээг сунгаж болно.</p>

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:



15. Алданги оногдуулах (ГЕН - 17)¹⁸	17.1	Нийлүүлэгч барааг нийлүүлж дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хойш хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх алдангийг ⁷ захиалагчид төлөх ба алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн 15 хувиас хэтрэхгүй. Энэхүү алданги нь үе шатны ажлын хуваарьт заасан ажил гүйцэтгэх хугацаанд нэгэн адил хамаарна. Нийлүүлэгчид олгох санхүүжилтийн дүнг алдангийн хэмжээгээр бууруулан олгоно.
	17.2	Нийлүүлэгчид олгох санхүүжилтийг хугацаа хоцроосон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх алдангийг захиалагчаас гүйцэтгэгчид төлөх бөгөөд алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн 15 хувиас хэтрэхгүй. Гүйцэтгэгчид алданги төлөх тохиолдолд гэрээний төлбөрийг алдангийн хэмжээгээр нэмэгдүүлнэ. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүжилт саатснаас үүсэх алдангийг захиалагч хариуцахгүй.
16. Маргааныг шийдвэрлэх (ГЕН - 21)	21.0	Талууд гэрээтэй холбоотой маргааныг зөвшилцөлийн зарчмаар шийдвэрлэх ба эс шийдвэрлсэн тохиолдолд Монгол улсын захиргааны хэргийн шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.
17. Урамшуулал	17.0	Гэрээгээр нийлүүлэгдэх барааг хуваариас өмнө хүргэсэн тохиолдолд нийлүүлэгчид мөнгөн урамшуулал олгохгүй.
18. Хохирлыг барагдуулах	18.0	Тухайн барааны шинж чанарын улмаас ямар нэг алдагдлыг (бүтээгдэхүүний хариуцлага болон гарах урсгал зардалтай холбогдсон гарсан хохиролыг нийлүүлэгч хариуцана.
19. Сэлбэг	19.0	Нийлүүлэгч тухайн барааг ажилуулах явцад шаардлагатай сэлбэг, хэрэгслийн жагсаалт, хаанаас авах боломжтой авах боломжтой тухай мэдэгдэл тайлбарыг захиалагчид гаргаж өгнө. Түүнчлэн барааг зайлшгүй дагалдах сэлбэг хэрэгслийг барааг дагалдуулан нийлүүлнэ.
20. Лиценз болон зөвшөөрөл	20.0	Барааг импортлох, нийлүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг нийлүүлэгч хариуцан авсан байна. Тухайн барааг ашиглахад шаардлагатй тусгай зөвшөөрөлийг захиалагч хариуцан эрх бүхий байгууллагаас авна.

ГЭРЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ:

**ЗАХИАЛАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**


ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗДТГ-ЫН
НИЙГМИЙН БОДЛОГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА, ТӨСЛИЙН
МЕНЕЖЕР


С.НАРАНТУЯА


Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын "А" байр
Утасны дугаар: 99568811

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

“ЭРХЭТ ХҮМҮҮН” ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР


Ц.БАЯНЖАРГАЛ

Улаанбаатар хот, ХУД, 15 дугаар
хороо, 32-2-3 тоот
Утас: 99993796, 88783025

Захиалагчийг төлөөлж: 

Гүйцэтгэгчийг төлөөлж: 

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

1. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа	
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа
1	2	3	4	5	6	7
1	Ахмадын өргөөний барилга	1	ш	Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сум	2020-07-09	2020-07-16

МАЯГТ ТШМ№1.2

2. Холбогдох үйчилгээний жагсаалт ба гүйцэтгэлийн хуваарь

	Үйчилгээний талаархи тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Үйчилгээг гүйцэтгэх газар болон ажлын талбай	Үйчилгээг гүйцэтгэж дуусгах огноо
1	Шаардлагатай тохиолдолд тухай бүр үйлчилгээ	1	ш	Хөвсгөл аймаг, Төмөрбулаг сум	

ГЭРЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ:

**ЗАХИАЛАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗДТГ-ЫН
НИЙГМИЙН БОДЛОГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА, ТӨСЛИЙН
МЕНЕЖЕР

 С.НАРАНТУЯА

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын “А”байр
Утасны дугаар: 99568811


**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

“ЭРХЭТ ХҮМҮҮН” ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР


 Н.БАЯНЖАРГАЛ

Улаанбаатар хот, ХУД, 15 дугаар
хороо, 32-2-3 тоот
Утас: 99993796, 88783025

Захиалагчийг төлөөлж: 

Гүйцэтгэгчийг төлөөлж: 

БАРААНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

БАТЛАВ:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  Ц.БАТТОГТОХ

ТӨМӨРБУЛАГ СУМАНД ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
БАРИГДСАН АХМАДЫН ӨРГӨӨНИЙ БАРИЛГЫГ УЛСЫН ТӨСВӨӨР
ТӨРИЙН ӨМЧИД ХУДАЛДАН АВАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Мөрөн сум

№ ...

2020.03.20

Барилгын үндсэн үзүүлэлт:

- Хийц – Модон
- Зориулалт – Ахмадын өргөө
- Давхар – 1 давхар
- Ашиглалтад орсон он - 2019


Төрийн өмчид улсын төсвөөр худалдан авах барилга байгууламжийн шаардлага:

- Ашиглалт - Улсын комисс ажиллуулж акт гаргуулсан байх
- Өмчлөлийн хэлбэр - Тухайн барилга нь барьсан иргэн хуулийн этгээдийн өөрийн өмч байх
- Барилгын үнэлгээ - Барилгад хөрөнгийн үнэлгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байх
- Зураг төсвийн шаардлага - Барилгын зураг төсөв нь магадлалаар орж баталгаажсан, эсвэл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраар хянан баталгаа хийлгэсэн байх
- Инженерийн хангамж - Инженерийн шугам сүлжээний мэргэжлийн байгууллагуудаас авсан техникийн нөхцөлтэй байх
- Эдэлбэр газрын шаардлага - Тухайн барилгын норм дүрэмд заасан стандартын дагуу авто зогсоол, ногоон байгууламж зэргийг багтаасан газартай байх ба газрын гэрээ гэрчилгээтэй байх

Боловсруулсан:

Аймгийн ерөнхий архитектор  Г.Бадамсэрээжид


Хянасан:

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн дарга  Э.Азаяа

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлөж:



Д/Д	БАРИЛГЫН НЭР	БАРИЛГЫН БҮТЭЦ	ХЭМЖЭЭ /М/	ХЭМЖЭЭ /М2/	ДАВХАРЫН ТОО	ӨРӨӨНИЙ ТОО	ЦОНХ	ХААЛГА	
								ТӨМӨР	МОДОН
1	Ахмадын өргөөний барилга	Палкаар барьсан, гадна талыг сайдингаар фасадласан, дотор тал нь ОСБ хавтангаар бүрсэн, 2 заал нь чулун шалтай, бусад өрөө нь паркет, хулдаас, Бүх цонх вакум цонхтой, модон хучилттай, шувуун нуруун төмөр дээвэртэй	18*14	392	2	15	30	3	15

г-ХНХЯЯ/20200222/1.3.8 дугаартай
гэрээний 5 дугаар хавсралт

САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРЬ

№	Барааны нэр, төрөл	Барааны үнэ /Төг/	Үүнээс: санхүүжилт олгох хугацаа	
			2020 онд	
			7-р сард	8-р сард
1	2	3	4	5
1	Ахмадын өргөөний барилга худалдан авах /Хөвсгөл, Төмөрбулаг сум/	200,000,000	200,000,000	

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний санхүүжилт COVID-19 цар тахлын аюулаас хамааран улсын төсөв бүрдээгүй, улсын эдийн засаг хүндрэх зэргээс хамаарч дээрх хүснэгтэд заасан хуваарийн дагуу санхүүжүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагч үүнээс үүсэх хариуцлага хүлээхгүй болно.

ГЭРЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ:

ЗАХИАЛАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗДТГ-ЫН
НИЙГМИЙН БОДЛОГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА, ТӨСЛИЙН
МЕНЕЖЕР

 С.НАРАНТУЯА


Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын “А” байр
Утасны дугаар: 99568811


ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

“ЭРХЭТ ХҮМҮҮН” ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР


 Ц.БАЯНЖАРГАЛ

Улаанбаатар хот, ХУД, 15 дугаар
хороо, 32-2-3 тоот
Утас: 99993796, 88783025

Захиалагчийг төлөөлж: 

Гүйцэтгэгчийг төлөөлж: 

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ




- 1. Нэр томъёо**
- 1.1. Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
- (а) “гэрээ” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд байгуулсан бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
 - (б) “гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн болон зохих хэмжээнд гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.
 - (в) “бараа” гэж нийлүүлэгчээс захиалагчид гэрээний дагуу нийлүүлэх тоног төхөөрөмж, машин механизм болон бусад материалыг хэлнэ.
 - (г) “бусад үйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, угсралт, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн үзүүлэх аливаа дагалдах ажил, үйлчилгээ, үүргийг хэлнэ.
 - (д) “захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
 - (е) “нийлүүлэгч” гэж гэрээнд заасан бараа, үйлчилгээг нийлүүлж буй этгээдийг хэлнэ.
 - (ж) “ажлын талбай” гэж гэрээний тусгай нөхцөлд тодорхойлсон газрыг хэлнэ.
 - (з) “хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
- 2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах**
- 2.1. Нийлүүлэгч нь захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задлаж болохгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.
- 2.2. Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч 2.1-т дурдсан баримт бичиг болон мэдээллийг гэрээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахгүй.
- 2.3. 2.1-т дурдсан гэрээнээс бусад баримт бичиг захиалагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв захиалагч хүсвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) захиалагчид буцааж өгнө.
- 2.4. Захиалагч нийлүүлэгчийн гэрээний гүйцэтгэлд хамаарах данс, бүртгэлийг шалгах эрхтэй ба аудитор томилж эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэх эрхтэй.
- 3. Захиалгыг өөрчлөх**
- 3.1. Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний ерөнхий цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгыг хэдийд ч өөрчлөх эрхтэй. Үүнд:

Захиалагчийг төлөөлж: Ц. Ганзориг

Гүйцэтгэгчийг төлөөлж: М. Баатаржав

- (а) гэрээний дагуу нийлүүлэгдэх барааг захиалагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар зураг, зураг төсөл, техникийн тодорхойлолтыг өөрчлөх;
- (б) тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр;
- (в) барааг хүргэх газар.
- 3.2. Нийлүүлэгч нь захиалгын өөрчлөлтийн (цаашид "өөрчлөлт" гэх) улмаас гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацаанд үзүүлэх нөлөөг (хэрэв нөлөөлөх бол) харгалзан түүний зардлын нарийвчилсан тооцоо, хэрэгжүүлэх хуваарийг гаргаж, өөрчлөлтийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор захиалагчид танилцуулна.
- 3.3. Захиалагч 3.2-т дурдсан нийлүүлэгчийн тооцоог үндэслэж өөрчлөлтийг бичгээр батлах ба ийнхүү баталгаажуулах хүртэл нийлүүлэгч 3.1-д дурдсан өөрчлөлтийг гүйцэтгэхгүй.
- 3.4. Харилцан тохиролцсон өөрчлөлт нь гэрээний хэсэг болох ба энэ өөрчлөлтөд гэрээний нөхцөл, болзол үйлчилнэ.
4. **Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах** 4.1. Энэхүү гэрээний 3 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчилж болохгүй. Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.
5. **Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах** 5.1. Захиалагч урьдчилж бичгээр зөвшөөрөөгүй тохиолдол нийлүүлэгч гэрээ болон түүний аль нэг хэсгийг туслан гүйцэтгүүлэх зорилгоор туслан гүйцэтгэгч сонгож түүнтэй гэрээ байгуулж болохгүй.
- 5.2. Нийлүүлэгч гэрээг хэрэгжүүлэхдээ сонгосон аливаа туслан гүйцэтгэгч нь өөрийн хариуцсан ажил үүрэгт ногдох гэрээний холбогдох нөхцөл, болзлыг бүрэн биелүүлэхийг батламжилна.
6. **Барааны гарал үүслийн улс** 6.1. Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно.
- 6.2. Барааны гарал үүслийн улс гэдэгт барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн газрыг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.
7. **Шалгалт болон туршилт** 7.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Гэрээний тусгай нөхцөлд эсвэл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгч(д)ийг нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.
- 7.2. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар, барааг хүргэх газар болон эцсийн цэгт явуулж болно. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар явуулсан тохиолдолд захиалагчийг шаардлагатай байгууламж, зураг, үйлдвэрлэлийн өгөгдөл болон бусад тусалцаагаар үнэ төлбөргүй хангана.

Захиалагчийг төлөөлж:




Гүйцэтгэгчийг төлөөлж:




- 7.3. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.
- 7.4. Барааг тээвэрлэхээс өмнө захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол Улсад орж ирсний дараа түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох захиалагчийн эрхийг хөндөхгүй.
- 7.5. Энэ зүйлийн аль ч нөхцөл, болзол нийлүүлэгчийг гэрээний баталгаат засварын болон бусад үүргээс чөлөөлөхгүй.
- 8. Баглаа боодол**
- 8.1. Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тундас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрт ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзсан байна.
- 8.2. Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичигийг бэлтгэхдээ гэрээнд, нэн ялангуяа гэрээний тусгай нөхцөлд заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.
- 9. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**
- 9.1. Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулга, хувилбарыг хэрэглэнэ. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад бичиг баримтыг бэлтгэж бүрдүүлнэ.
- 9.2. Гэрээнд хэрэглэсэн CIF /СИП/, EXW /ИКСБ/, FOB /ФОБ/, FCA/ФСА/, CIF /СИФ/ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
- 10. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх**
- 10.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглах явцад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн тохиолдолд гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.
- 11. Гүйцэтгэлийн баталгаа**
- 11.1. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан мөнгөн дүн бүхий гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор захиалагчид өгнө.
- 11.2. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж чадаагүйгээс захиалагчид учрах хохирлыг нөхөж барагдуулахад уг баталгаа зориулагдана. Гэрээний гүйцэтгэлийг ГЕН-ийн 16.2-ын дагуу сунгахад нийлүүлэгч мөн хугацаагаар гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй хугацааг сунгана.

Захиалагчийг төлөөлж:




Гүйцэтгэгчийг төлөөлж:




- 11.3. Гүйцэтгэлийн баталгаа нь ТООЗ-ны 16 дугаар зүйлд заасан валютаар гаргасан банкны баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр гаргасан баталгаа байна.
- 11.4. Нийлүүлэгч гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг дуусгавар болгосноос хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно.
- 12. Даатгал**
- 12.1. ГТН-д тусгайлан өөрөөр заагаагүй бол барааг үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах, болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалж бүх барааг ГТН-д заасан хэлбэрээр инкотермсийн нөхцөлийн дагуу даатгуулна.
- 13. Чанарын баталгаа, баталгаат засвар**
- 13.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, гэмтэл согоггүй бөгөөд хамгийн сүүлийн буюу өнөөгийн загварын, техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна. Өөрийн болон туслан гүйцэтгэгчийн бараа нийлүүлэхэд ашиглах бүх материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл зэрэг нь шинэ, сайн чанарын болон зориулалтынх байна гэдгийг нийлүүлэгч баталгаажуулна.
- 13.2. ГТН-д өөрөөр заагаагүй бол баталгаат засвар нь барааг хүргэж, ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сар, эсхүл барааны гарал үүслийн улсын боомтоос ачсан өдрөөс хойш 18 сар гэсэн хугацааны аль эрт дуусах хугацаанд хүчинтэй байна.
- 13.3. Захиалагч энэхүү баталгаатай холбогдох гомдлыг нийлүүлэгчид бичгээр шуурхай мэдэгдэнэ.
- 13.4. Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой бараа, эсхүл түүний эд ангийг үнэ төлбөргүй, шуурхай засварлах буюу солино.
- 13.5. Захиалагч нь 13.2 заасныг үл харгалзан, 13.4-т заасны дагуу гэмтэл согогийг арилгаснаас хойш 12 сарын дотор засварласан бараанд энэ төрлийн гэмтэл согог дахин гарсан тухай бичгээр мэдэгдэл ирвэл уг гэмтэл согогийг үнэ төлбөргүй шуурхай арилгана.
- 13.6. Хэрэв нийлүүлэгч гэмтэл согог гарсан мэдэгдэл хүлээн аваад гэрээний дагуу түүнийг арилгахгүй бол захиалагч өөрөө нийлүүлэгчийн зардлаар уг гэмтэл согогийг арилгах эрхтэй. Энэ зүйлд заасны дагуу нийлүүлэгчийн гаргах баталгаа нь гэрээнд заасан захиалагчийн бусад эрх, үйл ажиллагааг хязгаарлахгүй.
- 14. Төлбөр**
- 14.1. Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг ГТН-д дурдана.
- 14.2. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараагаар төлбөр хийхийг хүссэн хүсэлтийг төлбөрийн нэхэмжлэх болон ГЕН-ийн 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ.
- 14.3. ГТН-д өөрөөр заагаагүй бол захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ.
- 14.4. Гэрээний дагуу нийлүүлэгчид хийх төлбөрийг тендерийн маягтад дурдсан валютаар хийнэ.

Захиалагчийг төлөөлж:




Гүйцэтгэгчийг төлөөлж:




15. Үнэ 15.1. Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон үнийг баримтлана. ГТН-ийн үнэ тохируулах нөхцөлийн дагуу үнийг тохируулах эсхүл ГЕН-ийн 3 дугаар зүйлийн дагуу захиалгыг өөрчлөхөд тендерт санал болгосон үнэ өөрчлөгдвөл, өөрчлөгдсөн үнийг баримтлана.
16. Хуваарийг сунгах 16.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
- 16.2. Нийлүүлэгч дараах тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарийг сунгах тухай хүсэлт гаргаж болно. Үүнд:
- (а) захиалагч ГЕН-ийн 3 дугаар зүйлд заасны дагуу захиалгыг өөрчилсөн;
 - (б) захиалагчаас гаргаж өгөх материал, зураг, эсхүл үйлчилгээ хугацаа хоцорсон (үйлчилгээ гэдэгт гэрээний дагуу захиалагчийн гаргах зөвшөөрөл, баталгаа орно);
 - (в) ГЕН-ийн 22 дугаар зүйлд заасан гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүсвэл;
 - (г) захиалагчийн өгсөн захиалгаас шалтгаалан ажлын гүйцэтгэл хойшилсон.
- Нийлүүлэгч хугацаа хоцрохоос урьдчилан сэргийлэхийн тулд бололцоотой бүхнийг хийсэн гэдгийг захиалагчид нотлон харуулах үүрэгтэй. Хугацаа хоцролтын шалтгааныг арилгах, даван туулах арга замуудыг талууд хэлэлцэнэ.
- 16.3. Гүйцэтгэгч 16.2-т заасан нөхцөл байдал бий болсны улмаас бараа нийлүүлэлтийн хуваарь ямар нэг байдлаар хоцорч болох тухай захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдээгүй, эдгээр нөхцөл байдал бий болсныг нотлон харуулаагүй тохиолдолд 16.2-ыг үл харгалзах ба хуваарийг сунгахгүй.
17. Алданги оногдуулах 17.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг уг хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэх ёсгүй. Дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд захиалагч ГЕН-ийн 18 дугаар зүйлийн дагуу цуцлах тухай асуудлыг хөндөж болно.
18. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах 18.1. Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад арга хэрэгслийг ашиглалгүйгээр нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Үүнд:
- (а) нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд хүргэж чадаагүй;
 - (б) нийлүүлэгчийн ирүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаарлага хангаагүй бөгөөд гэрээний бусад үүргээ биелүүлээгүй;
 - (в) нийлүүлэгч 18.1.(а), 18.1.(б)-д заасан нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг захиалагчаас хүлээн аваад 10 хоногийн дотор (захиалагч үүнээс урт хугацаа заах эрхтэй) алдаагаа залруулаагүй;

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:




- 22.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
23. **Гэрээний үүргийг шилжүүлэх** 23.1. Ямарч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
24. **Гэрээнд ашиглах хэл** 24.1. Нийлүүлэгч ГТН-д заасан гэрээнд ашиглах хэлийг бүрэн ойлгох мэдлэгтэй гэдгээ үүгээр баталж байна. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.
- 24.2. 24.1-д заасан хэл рүү орчуулах зардал болон орчуулгын үнэн зөвийг нийлүүлэгч хариуцна.
25. **Татвар болон хураамж** 25.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оногдуулдаг бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.
26. **Гарчиг** 26.1. Гэрээний бүлэг, зүйл болон бусад хэсгийн гарчиг нь зөвхөн тайлбарын шинжтэй бөгөөд гэрээний хэсэг болохгүй.
27. **Үүргийн гүйцэтгэл** 27.1. Аль нэг тал нь гэрээний үүргээ гүйцэтгэхийг хатуу шаардаагүй нь нөгөө талын уг үүргийг биелүүлэхгүй байх шалтгаан болохгүй.

ГЭРЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ:

**ЗАХИАЛАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗДТГ-Ы
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙ
ДАРГА, ТӨСЛИЙН МЕНЕЖЕР


 С.НАРАНТУЯА

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын “А” байр
Утасны дугаар: 99568811

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

“ЭРХЭТ ХҮМҮҮН” ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР


4141334 + СБА5114


 У. БАЯНТАРГАЛ

ЭРХЭТ ХҮМҮҮН
ХХК

Улаанбаатар хот, ХУД, 15 дугаар
хороо, 32-2-3 тоот

Утас: 99993796, 88783025

Захиалагчийг төлөөлж: 

Гүйцэтгэгчийг төлөөлж: 

1.6 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

1.7 Гэрээ нь энд дурдсан бараа нийлүүлэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

1.8 Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл түүний хавсралтад заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлж, хариуцлагыг хүлээнэ.

1.9 Гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн баталгааг барааг нийлүүлсэн тухай мэдэгдэл (Барааг хүлээн авах акт) гарснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байлгана. Бараа нийлүүлэлт дуусаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгааг чөлөөлөхийг хориглох бөгөөд баталгаа чөлөөлсөн нөхцөлд захиалагчийн шийдвэрээр гэрээг цуцлана.

1.10 Барааны баталгааг засварын хугацаа буюу барааны чанарын баталгааны хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг сүүлийн санхүүжилтээс суутган тооцож 1 жилийн хугацаанд Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн дансанд байршуулна.

1.11 Барааг захиалагчийн ажлын хэсэгт хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацааны 1 жилийн хугацаанд бараанд гарсан гэмтэл согог, зөрчил, гологдлыг засварлах шаардлага гарсан тохиолдолд захиалагч нь гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэнэ. Гүйцэтгэгч нь захиалагчийн хүсэлтийн дагуу зөрчил гологдлыг арилгах, шинэ бараагаар солих үүрэг хүлээнэ.

1.12 Нийлүүлэгч нь гэрээний 1.11 дахь хэсэгт заасан мэдэгдэл авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гүйцэтгээгүй тохиолдолд захиалагч энэхүү гэрээний 1.10 дахь хэсэгт заасан барьцаа хөрөнгөөс гарган гологдол, гэмтлийг арилгах ажлыг бусад этгээдээр гүйцэтгүүлэх буюу үүргээ гүйцэтгээгүй нийлүүлэгчийг “Тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл”-д бүртгүүлэхээр холбогдох байгууллагад хандана.

1.13 Бараа нийлүүлэх гэрээний төлбөрийг санхүүжилтийн хуваарийн дагуу гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжүүлэх бөгөөд гэрээний төлбөрийн үлдэгдлийг барааг бүрэн нийлүүлж, холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгсний дараа олгоно.

1.14 Бараа нийлүүлэх гэрээний төлбөр нь нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөхгүй.

1.15 Зайлшгүй шаардлагаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож гэрээний үнэ, барааны техникийн тодорхойлолтоос бусад асуудлаар зохих өөрчлөлт оруулж болох бөгөөд тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд хүчин төгөлдөр болсонд тооцно.

1.16 Нийлүүлэгчид олгох гэрээний төлбөрөөс дараах зардлуудыг захиалагчийн холбогдох дансанд суутгана. Үүнд:

- Гэрээ байгуулах бичиг хэргийн материалын үнэ, барааг хүлээн авах, түршилт тохируулга хийх, ашиглалтад оруулах, чанарын баталгааны барьцаа хөрөнгийг чөлөөлөхөд ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай зардал: **400,000 (Дөрвөн зуун мянган)** төгрөг
- Барааг захиалагч хүлээн авахаас өмнө гарсан урсгал зардал **0,0** төгрөг

1.17 Захиалагч нь Иргэний хуулийн 254 дүгээр зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлнэ.

1.18 Нийлүүлэгч нь Иргэний хуулийн 253 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлнэ.

1.19 Захиалагч нь гэрээний дагуу бараа нийлүүлэлт болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөр төлөх, чанарын баталгааны барьцаа хөрөнгийг чөлөөлөн нийлүүлэгчид олгох үүрэг хүлээнэ.

1.20 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.

ХОЁР.ГЭРЭЭНИЙ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА


2.1 Нийлүүлэгч нь барааны тендерт өөрийн ирүүлсэн баримт бичиг, ажлын гүйцэтгэлийн талаар бүрдүүлж өгсөн зураг, төсөв, баримт материалын үнэн зөвийг бүрэн хариуцна.

2.2 Талууд бие биенийхээ өмнөөс гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:



нөхцөл, гүйцэтгэлийн баталгаа болон энэ гэрээний 1.5 дахь хэсэгт заасан баримт бичгүүд нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3 Энэхүү гэрээний нөхцөлд гэрээнд заасан барааны техникийн тодорхойлолт, тоо хэмжээ, үнэ өөрчлөхөөс бусад асуудлаар өөрчлөлт оруулж болох бөгөөд уг өөрчлөлт нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

ТАВ. ГЭРЭЭ ДҮГНЭХ

5.1 Захиалагчийн төслийн баг нь нийлүүлэгч байгууллагатай хамтран барааг захиалагчид хүлээн авах ажиллагааг зохион байгуулж, бараа нийлүүлэх гэрээг дүгнэнэ.

5.2 Бараа нийлүүлэлтийн үндсэн гэрээ болон нэмэлт гэрээг тухайн үе шатанд хийгдсэн нийлүүлэлт, гэрээний бусад нөхцлийг үндэслэн дүгнэнэ.

ГЭРЭЭНИЙ НӨХЦЛИЙГ ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗДТГ-ЫН ДАРГА


Х.ГАН-ОЧИР

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын "А" байр
Утасны дугаар: 70388699

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗРЫН ДАРГА


Б.БОЛД

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын "А" байр
Утасны дугаар:
70388849

ХЯНАСАН:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ
ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА


Г.ГАНДЭЛГЭР

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын "А" байр
Утасны дугаар: 70382751

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ЭРХЭТ ХҮМҮҮН” ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР


Ц.БАЯНЖАРГАЛ

Улаанбаатар хот, ХУД, 15 дугаар
хороо, 32-2-3 тоот


Утас: 99993796, 88783025

Харилцагч банкны нэр: ХААН
банк


Дансны дугаар: 5916090422

Регистрийн дугаар: 4141334

Захиалагчийг төлөөлж: _____



Гүйцэтгэгчийг төлөөлж: _____



ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Гэрээний ерөнхий нөхцөлийн заалтын дугаар	Ерөнхий нөхцөлийн дэд дугаар	Тусгай нөхцөлийн заалт
1. Тодорхойлолт (ГЕН - 1)	1.1.(д)	Захиалагч нь <i>Хөвсгөл аймгийн Засаг дарга</i> .
	1.1	Төсөл арга хэмжээний нэр: <i>Ахмадын өргөөний барилга</i> 053 <i>худалдан авах /Хөвсгөл, Төмөрбулаг сум/</i>
	1.1	Гэрээний дугаар: г-ХНХЯ/202002022/1.3.8
	1.1(г)	Бусад үйлчилгээ “Шаардлагатай” ”Үгүй” гэх сонголтыг дараах үйлчилгээний ард нь тэмдэглэнэ. Үүнд: 1. тээвэрлэлт- <i>шаардлагагүй</i> 2. даатгал болон бусад дагалдах үйлчилгээ - <i>шаардлагатай</i> 3. угсралт – <i>үгүй /баригдсан барилга/</i> 4. техникийн туслалцаа - <i>шаардлагатай</i> 5. сургалт - <i>үгүй</i>
	1.1 (ж)	Барааг <i>Барилга байгууламжийн байрлаж буй газарт хүлээн авна.</i>
6. Шалгалт туршилт (ГЕН - 7)	7.1	Барааг тээвэрлэхээс өмнө захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол Улсад орж ирсэний дараа түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох захиалагчийн эрхийг хөндөхгүй.
	7.2	Нийлүүлэгч нь барааг захиалагчаас тогтоосон цэгт хүргэхийн өмнө түүний техникийн тодорхойлолт, үйлдвэрийн өгөгдөл, гарал үүслийн гэрчилгээ, техникийн паспорт зэрэг баримт бичгийг ирүүлж, ба захиалагч нь барааг хүлээн авах эсэх санал болон барааг шалгаж туршихаар томилогдсон төлөөлөгч(д)-ийг мэдээллийг албан бичгээр нийлүүлэгчид хүргүүлнэ.
	7.3	Гэрээний тусгай нөхцөлд заасан газарт ирүүлсэн бараанд дараах шалгалт, туршилтыг хийнэ. Үүнд: Захиалагчийн техникийн тодорхойлолт, холбогдох стандартын заалт нэг бүрийг хангаж буй эсэхийг нийлүүлэхээр санал болгосон барааны үйлдвэрийн өгөгдөл, техникийн паспорт, гарал үүслийн гэрчилгээнд заасан өгөгдөлтэй нэг бүрчлэн тулгаж шалгана.
	7.4	Барилга байгууламжийг хүлээн авахдаа барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-аар магадлалыг дүгнэлттэй зураг төсөвтэй тулган шалгаж барилга байгууламжийг барих ил болон далд ажлын актын баталгаажилт, улсын комиссын актыг үндэслэн хүлээн авна.
	7.5	Барааны зориулалт, шинж чанар, онцлог байдлаас хамааруулж бусад туршилт, шалгалтыг явуулж болно.
7. Баглаа боодол (ГЕН - 8)	8.1	Хүлээлгэн өгөх барилга нь ахмадын өргөөний зориулаллалтаар ашиглагахад стандарт шаардлагыг хангасан тухай мэргэжлийн байгууллагын дүгнэлт шийдвэртэй байна. Ашиглалтад хүлээлгэн өгөхдөө барилга гэрээний 4 дүгээр хавсралт техникийн нөхцөлд заасан баримтыг бүрдүүлсэн байна.
8. Барааг хүргэх болон бичиг баримтын	9.0	ГЕН-ийн 9 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: ¹² “Монгол Улсын гаднаас санал болгосон бараа жишээлбэл СИП: Нийлүүлэгч барааг тээврийн хэрэгсэлд ачсаны дараа энэ тухай бүрэн мэдээллийг захиалагч болон даатгалын байгууллагад утсан

Захиалагчийг төлөөлж:


У.У.У

Гүйцэтгэгчийг төлөөлж:


А. Даянторгал

		<p>1. Урьдчилгаа төлбөр: Хэрэв тендерийн баримт бичигт заасан тохиолдолд гэрээний үнийн 10 хувьтай тэнцэх дүнг гэрээнд гарын үсэг зурснаас хойш 30 хоногийн дотор гүйцэтгэгчийн гаргаж ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн төлнө. Урьдчилгаа төлбөрийн баталгаа нь бараа нийлүүлэгдэх хүртэлх хугацаанд хүчинтэй, урьдчилгаа төлбөрийн хэмжээтэй тэнцэх дүнтэй, тендерийн баримт бичигт заасан маягтын дагуу захиалагч хүлээн зөвшөөрөхүйц банкны баталгаа, Засгийн газрын бонд хэлбэрээр байна.</p> <p>2. Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр: Бараа ачигдсаны дараа барааны гэрээний үнийн 70 хувьтай тэнцэх дүнг гэрээний ерөнхий нөхцөлийн 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийг үндэслэн буцаан үл дуудах баталгаат аккредитивээр төлнө.</p> <p>3.¹⁴ Барааг хүлээн авахад төлөх төлбөр: Гэрээний төлбөрийн үлдэгдэл (20 хүртэл хувь)-ийг барааг бүрэн хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх болон гэрээг дүгнэсэн акт, захиалагчийн барааг хүлээн авсан тухай акт, бусад баримт бичгийг үндэслэн төлнө.</p>
13. Үнэ (ГЕН - 15)	15.1	<p>1. Барааны суурь үнэ 15%¹⁷ хувиас илүү өсөх, эсхүл буурахаар бол үнийг тохируулах бусад тохиолдолд үнэ тохируулахгүй.</p> <p>2. Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон үнийг баримтлана.</p> <p>3. Захиалгыг өөрчлөхгүй.</p> <p>4. Тендерт оролцогч индексийн эх үүсвэр болон суурь өдрийн индексийг өөрийн тендерт зааж өгнө. Суурь өдөр нь тендер зарласан өдөр байна.</p>
14. Бараа нийлүүлэлтийн хуваарийг сунгах (ГЕН - 16)	16.2	<p>Нийлүүлэгч гэрээ болон нийлүүлэлтийн хуваарийг сунгах хүсэлтийг гэрээний нийлүүлэлтийн хуваарь дуусахаас 7-оос доошгүй хоногийн өмнө захиалагчид бичгээр гаргана. Захиалагч нийлүүлэгчийн хүсэлтийг судлан “Гэрээний ерөнхий нөхцлийн “Хуваарийг сунгах” гэх гэрээний ерөнхий нөхцлийн 16.2 дахь хэсэгт заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд гэрээг сунгаж болно.</p>

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:



15. Алданги оногдуулах (ГЕН - 17)¹⁸	17.1	Нийлүүлэгч барааг нийлүүлж дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хойш хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх алдангийг ⁷ захиалагчид төлөх ба алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн 15 хувиас хэтрэхгүй. Энэхүү алданги нь үе шатны ажлын хуваарьт заасан ажил гүйцэтгэх хугацаанд нэгэн адил хамаарна. Нийлүүлэгчид олгох санхүүжилтийн дүнг алдангийн хэмжээгээр бууруулан олгоно.
	17.2	Нийлүүлэгчид олгох санхүүжилтийг хугацаа хоцроосон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх алдангийг захиалагчаас гүйцэтгэгчид төлөх бөгөөд алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн 15 хувиас хэтрэхгүй. Гүйцэтгэгчид алданги төлөх тохиолдолд гэрээний төлбөрийг алдангийн хэмжээгээр нэмэгдүүлнэ. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүжилт саатснаас үүсэх алдангийг захиалагч хариуцахгүй.
16. Маргааныг шийдвэрлэх (ГЕН - 21)	21.0	Талууд гэрээтэй холбоотой маргааныг зөвшилцөлийн зарчмаар шийдвэрлэх ба эс шийдвэрлсэн тохиолдолд Монгол улсын захиргааны хэргийн шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.
17. Урамшуулал	17.0	Гэрээгээр нийлүүлэгдэх барааг хуваариас өмнө хүргэсэн тохиолдолд нийлүүлэгчид мөнгөн урамшуулал олгохгүй.
18. Хохирлыг барагдуулах	18.0	Тухайн барааны шинж чанарын улмаас ямар нэг алдагдлыг (бүтээгдэхүүний хариуцлага болон гарах урсгал зардалтай холбогдсон гарсан хохиролыг нийлүүлэгч хариуцана.
19. Сэлбэг	19.0	Нийлүүлэгч тухайн барааг ажилуулах явцад шаардлагатай сэлбэг, хэрэгслийн жагсаалт, хаанаас авах боломжтой авах боломжтой тухай мэдэгдэл тайлбарыг захиалагчид гаргаж өгнө. Түүнчлэн барааг зайлшгүй дагалдах сэлбэг хэрэгслийг барааг дагалдуулан нийлүүлнэ.
20. Лиценз болон зөвшөөрөл	20.0	Барааг импортлох, нийлүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг нийлүүлэгч хариуцан авсан байна. Тухайн барааг ашиглахад шаардлагатй тусгай зөвшөөрөлийг захиалагч хариуцан эрх бүхий байгууллагаас авна.

ГЭРЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗДТГ-ЫН
НИЙГМИЙН БОДЛОГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА, ТӨСЛИЙН
МЕНЕЖЕР



С.НАРАНТУЯА

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын “А” байр
Утасны дугаар: 99568811


ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ЭРХЭТ ХҮМҮҮН” ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР


 Ц.БАЯНЖАРГАЛ

Улаанбаатар хот, ХУД, 15 дугаар
хороо, 32-2-3 тоот
Утас: 99993796, 88783025

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:



БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

1. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа	
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа
1	2	3	4	5	6	7
1	Ахмадын өргөөний барилга	1	ш	Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сум	2020-07-09	2020-07-16

МАЯГТ ТШМ№1.2

2. Холбогдох үйчилгээний жагсаалт ба гүйцэтгэлийн хуваарь

	Үйлчилгээний талаархи тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Үйлчилгээг гүйцэтгэх газар болон ажлын талбай	Үйлчилгээг гүйцэтгэж дуусгах огноо
1	Шаардлагатай тохиолдолд тухай бүр үйлчилгээ	1	ш	Хөвсгөл аймаг, Төмөрбулаг сум	

ГЭРЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ:

**ЗАХИАЛАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗДТГ-ЫН
НИЙГМИЙН БОДЛОГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА, ТӨСЛИЙН
МЕНЕЖЕР

 С.НАРАНТУЯА


Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын “А” байр
Утасны дугаар: 99568811

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

4141334 + СБА5114

“ЭРХЭТ ХҮМҮҮН” ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР


ЭРХЭТ ХҮМҮҮН
ХХК

 Б.БАЯНЖАРГАЛ

9012120247

Улаанбаатар хот, ХУД, 15 дугаар
хороо, 32-2-3 тоот
Утас: 99993796, 88783025

Захиалагчийг төлөөлж: 

Гүйцэтгэгчийг төлөөлж: 

БАРААНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

БАТЛАВ:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  Ц.БАТТОГТОХ

ТӨМӨРБУЛАГ СУМАНД ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
БАРИГДСАН АХМАДЫН ӨРГӨӨНИЙ БАРИЛГЫГ УЛСЫН ТӨСВӨӨР
ТӨРИЙН ӨМЧИД ХУДАЛДАН АВАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Мөрөн сум

№ ...

2020.03.20

Барилгын үндсэн үзүүлэлт:

- Хийц – Модон
- Зориулалт – Ахмадын өргөө
- Давхар – 1 давхар
- Ашиглалтад орсон он - 2019


Төрийн өмчид улсын төсвөөр худалдан авах барилга байгууламжийн шаардлага:

- Ашиглалт - Улсын комисс ажиллуулж акт гаргуулсан байх
- Өмчлөлийн хэлбэр - Тухайн барилга нь барьсан иргэн хуулийн этгээдийн өөрийн өмч байх
- Барилгын үнэлгээ - Барилгад хөрөнгийн үнэлгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байх
- Зураг төсвийн шаардлага - Барилгын зураг төсөв нь магадлалаар орж баталгаажсан, эсвэл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраар хянан баталгаа хийлгэсэн байх
- Инженерийн хангамж - Инженерийн шугам сүлжээний мэргэжлийн байгууллагуудаас авсан техникийн нөхцөлтэй байх
- Эдэлбэр газрын шаардлага - Тухайн барилгын норм дүрэмд заасан стандартын дагуу авто зогсоол, ногоон байгууламж зэргийг багтаасан газартай байх ба газрын гэрээ гэрчилгээтэй байх


Боловсруулсан:

Аймгийн ерөнхий архитектор  Г.Бадамсэрээжид


Хянасан:

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн дарга  Э.Аззаяа

Захиалагчийг төлөөлж:



Гүйцэтгэгчийг төлөөлж:



Д/Д	БАРИЛГЫН НЭР	БАРИЛГЫН БҮТЭЦ	/М/ СӨЖМӨХ	/М2/ ХЭМЖЭЭ	ДАВХАРЫН ТОО	ӨРӨӨНИЙ ТОО	ЦОНХ	ХААЛГА	
								ТӨМӨР	МОДОН
1	Ахмадын өргөөний барилга	Палкаар барьсан, гадна талыг сайдингаар фасадласан, дотор тал нь ОСБ хавтангаар бүрсэн, 2 заал нь чулун шалтай, бусад өрөө нь паркет, хулдаас, Бүх цонх вакум цонхтой, модон хучилттай, шувуун нуруун төмөр дээвэртэй	18*14	392	2	15	30	3	15

г-ХНХЯЯ/202002022/1.3.8 дугаартай
гэрээний 5 дугаар хавсралт

САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРЬ

№	Барааны нэр, төрөл	Барааны үнэ /Төг/	Үүнээс: санхүүжилт олгох хугацаа	
			2020 онд	
			7-р сард	8-р сард
1	2	3	4	5
1	Ахмадын өргөөний барилга худалдан авах /Хөвсгөл, Төмөрбулаг сум/	200,000,000	200,000,000	

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний санхүүжилт COVID-19 цар тахлын аюулаас хамааран улсын төсөв бүрдээгүй, улсын эдийн засаг хүндрэх зэргээс хамаарч дээрх хүснэгтэд заасан хуваарийн дагуу санхүүжүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагч үүнээс үүсэх хариуцлага хүлээхгүй болно.

ГЭРЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ:

**ЗАХИАЛАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗДТГ-ЫН
НИЙГМИЙН БОДЛОГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА, ТӨСЛИЙН
МЕНЕЖЕР


С.НАРАНТУЯА


Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын "А"байр
Утасны дугаар: 99568811

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

“ЭРХЭТ ХҮМҮҮН” ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

 Ц.БАЯНЖАРГАЛ

Улаанбаатар хот, ХУД, 15 дугаар
хороо, 32-2-3 тоот
Утас: 99993796, 88783025

Захиалагчийг төлөөлж: 

Гүйцэтгэгчийг төлөөлж: 